

Шүтэн барилдлага уу? эсвэл харилцан оршихуй юу?

Сүхбагын Соёлмаа

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

soyolmaas@mas.ac.mn

Хураангуй

Монгол оронд буддизм нь Юань гүрний үед буюу XIV дүгээр зуунд соёл, нийгэм улс төрийн өргөн хүрээнд түгэн дэлгэрчээ. Ийнхүү буддизм нь Монголын бөө мөргөл, тэнгэрзм гэх мэт уугуул шашнуудтай адилсал ондоошилд орсоор, янз бүрийн өнгө аястай хөгжиж ирсэн юм. Сүүлийн үеийн социологийн судалгааны дүн мэдээнээс харахад Монголчуудын ихэнх нь буддын шашинтай хэвээр байна гэх боловч сургаал номлолыг нь мэддэг, шүтдэг хүн ховор байгааг харж болно. Ихэнх нь л сохроор итгэж найдаж байгаа мэт. Ерөөс философи гэдэг бол юу байсныг биш, өнөөдөр, энд, бидний хувьд юу байх ёстойг шинжилдэг. Яг одоо гэдэг бол 10 жилийн өмнөхөөс шал ондоо учраас бид аливаа ойлголт, ухагдахууныг аль болох орчин үеийнхээ асуудлыг шийдэх талаас нь шинэчилж байх шаардлагатай юм. Тиймээс буддын философийн ойлголтуудыг орчин цагийн хэл дээр хөрвүүлэх, тайлбарлах, өнөөгийн хүмүүст тулгарч буй асуудлуудыг шийдэх өнцгөөс нь хандаж байгаа шинжлэх ухааны бүтээлүүд Монголд ховор байсаар л байна. Буддизмыг судлаачид архаик (эрт дээр үеийн) утгаар нь тайлбарлах чиг хандлага, арга зүй зонхилсоор л байна.

Уламжлалаа авч үлдэх нь тухайн үзэгдлийн өөрийн мөн чанарыг хадгалж үлдэх ач холбогдолтой хэдий ч бид бол хэл шинжлэлийн философич Л.Витгенштейний хожуу үеийн арга зүйг баримталж байгаа бөгөөд түүний үзлээр хэл бол ярианы адил хандаж буй аудиторын уур амьсгал, нөхцөл байдлаас шалтгаалж, уян хатан, динамик шинжтэй байдаг. Ийм зорилгын үүднээс бид энэ өгүүлэлдээ их хөлгөний буддизмын (махаяна) мадхьямика чиглэл буюу төв үзэл, дунддын тухай философийг сүүлийн үеийн судалгаа шинжилгээний бүтээлд тулгуурлан утга зүйн үүднээс шинжилж өөрсдийн таамгийг дэвшүүлсэн юм. Ерөнхийдөө хэлэлцүүлгийн үр дүнд бид их хөлгөний буддизмын мадхьямика философийг шүтэн барилдахуйн философи гэхээсээ **харилцан оршихуйн философи** хэмээн ойлгож, тайлбарлах нь илүү орчин үеийнх болно гэсэн санаа юм.

Түлхүүр үгс: *яриа, дундад, их хөлгөн, ухамсар, оршихуй, гэгээрэл, би үгүй*

Worshiped association? or Mutual existence?

Soyolmaa Sukhbat

Doctor (Ph.D)

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia

soyolmaas@mas.ac.mn

Abstract:

Buddhism spread to Mongolia in the 14th century. Thus, Buddhism continued to evolve in different shades in harmony with ancient religions such as Mongolian Shamanism and Tengism. According to recent sociological studies, the majority of Mongolians still follow Buddhism, but few know and worship it. Most people seem to be blindly believing and hoping.

According to recent sociological surveys, it is clear that most Mongolians still practice Buddhism, but few know and worship its teachings. Most of them seem to have blind faith and hope. In general, philosophy analyzes not what was, but what should be today, here, for us.

We need to update all concepts and concepts as far as possible to solve modern problems, because they are the same as they were 10 years ago. Therefore, Mongolia still has rare scientific literature, translating Buddhist philosophical concepts into modern languages and solving human problems. The direction and methodology of interpreting Buddhism in the ancient sense are still common among scholars. The preservation of tradition is important to preserve the essence of phenomena, but we follow the method of the late philosopher L. Wittgenstein believes that language is flexible and dynamic, depending on the audience's environment and situation, and is treated as a language.

Modernization of Buddhism's concepts and categories is necessary so that everyone can read it in modern Mongolian, bring it closer to civil education and critically evaluate it. To this end, we analyze the Madhyamika philosophy of Mahayana Buddhism based on recent studies and research in terms of semantics. Overall, the discussion suggests that understanding and explaining Mahayana Buddhist philosophy as the philosophy of mutual existence is more contemporary than the philosophy of worship (in Mongolian, Shuten Barildlaga).

Keywords: *speech, medium, Mahayana, consciousness, existence, Nirvana, without Self*

I. Оршил.

Монгол оронд буддизм нь Юань гүрний үед буюу XIV дүгээр зуунд соёл, нийгэм улс төрийн өргөн хүрээнд түгэн дэлгэрчээ. Ийнхүү буддизм нь Монголын бөө мөргөл, тэнгэрлэг гэх мэт уугуул шашнуудтай адилсал ондоошилд орсоор, янз бүрийн өнгө аястай хөгжиж ирсэн юм. Сүүлийн үеийн социологийн судалгааны дүн мэдээнээс харахад Монголчуудын ихэнх нь буддын шашинтай хэвээр байна гэх боловч сургаал номлолыг нь мэддэг, шүтдэг хүн ховор байгааг харж болно. Ихэнх нь сохроор итгэж найдаж байгаа мэт. Социологийн судалгааны хувьд жишээ нь “та ямар шашинтай вэ?” гэж асуухаар би буддын шашинтай гэж хариулах хүн олон ч гэсэн арай лавшруулаад “та тэгвэл хоосон чанар гэдгийг юу гэж ойлгодог вэ? гэж асуувал хариулах хүн ховор юм.. Орчин үеийн залуучуудад хоосон чанарын гүн ухаанаар бол ингэнэ тэгнэ гэж сургавал бараг урдаас “юу яриад байна” гэж гайхах хүн бодит амьдрал дээр олон байдаг. Ерөөс философи гэдэг бол юу байсныг

биш, өнөөдөр, энд, бидний хувьд юу байх ёстойг шинжилдэг (Y.Park 2023, 16) хэмээн Солонгосын орчин үеийн философич бичсэн байна. Бид үүнтэй санал нэг байгаа бөгөөд яг одоо гэдэг бол 10 жилийн өмнөхөөс шал ондоо учраас бид аливаа ойлголт, ухагдахууныг орчин үеийнхээ асуудлыг шийдэх талаас нь шинэчлэх шаардлагатай юм.

II. Судалгааны арга зүй

Тиймээс буддын философийн ойлголтуудыг орчин цагийн хэл дээр хөрвүүлэх, тайлбарлах, өнөөгийн хүмүүст тулгарч буй асуудлуудыг шийдэх өнцгөөс нь хандаж байгаа шинжлэх ухааны бүтээлүүд Монголд ховор байсаар л байна. Буддизмыг судлаачид архаик (эрт дээр үеийн) утгаар нь тайлбарлах чиг хандлага, арга зүй зонхилсоор л байна. Философийн шинжлэх ухааны доктор М.Гантуяа “Монгол нэрс нь Мэргэд гарахын орны уламжлалт орчуулгыг ашигласан тул цаашид эдгээр монгол нэрсийг Буддын философийн ном зохиолын орчуулгад нэг мөр хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна” (М.Гантуяа 2021) хэмээн бичсэн байна. Зарим талаараа уламжлалаа авч үлдэх нь тухайн үзэгдлийн өөрийн мөн чанарыг хадгалж үлдэх ач холбогдолтой хэдий ч бид бол хэл шинжлэлийн философич Л.Витгенштейний хожуу үеийн арга зүйг баримталж байгаа бөгөөд түүний үзлээр хэл бол ярианы адил хандаж буй аудиторын уур амьсгал, нөхцөл байдлаас шалтгаалж, уян хатан, динамик шинжтэй байдаг. Тиймээс буддизмын ойлголт, категорийг орчин үеийн Монгол хэл дээр хэн ч уншихаар ойлгогдохоор, иргэний боловсролд дөхүүлж орчин үечүүлж, шүүмжлэн дүгнэх шаардлагатай байгаа юм.

III. Судалгааны үр дүн

Ийм зорилгын үүднээс бид энэ өгүүлэлдээ их хөлгөний буддизмын (махаяна) мадхьямика чиглэл буюу төв үзэл, дундын тухай философийг сүүлийн үеийн судалгаа шинжилгээний бүтээлд тулгуурлан утга зүйн үүднээс шинжилж өөрсдийн таамгийг дэвшүүлсэн юм. Ерөнхийдөө хэлэлцүүлгийн үр дүнд бид их хөлгөний буддизмын мадхьямика философийг шүтэн барилдахуйн философи гэхээс илүү **харилцан оршихуйн (relational existence) философи** хэмээн ойлгож, тайлбарлах нь илүү орчин үеийнх болно гэсэн санаа юм.

IV. Судалгааны хэлэлцүүлэг

Харилцан оршихуй хэмээх үгийн харилцан хэмээх үг нь англи хэлний relation, relational, эсвэл dependence, Орос хэлний отношение, зависимость гэсэн үгнүүдтэй дүйцэж байна. Харин оршихуй хэмээх нь англиар existence, оросоор существование хэмээх үгийн утга бол Хайдегерийн философийн үүднээс бол дозайн буюу хүний оршихуй юм. Гэхдээ Мадхьямика философид ярьдаг оршихуй бол зөвхөн хүний оршихуй бус, бүхий л үзэгдэл, амьтан ургамал гэх мэт амьтай юмс ба хүн хоорондын харилцан байхуй юм. Нэрт дорно дахин судлаач Е.А.Торчинов нь “Нагаржунагийн гол гаргалгаа нь “юу ч (ямар ч дхарм) өөрийн ахуйтай байдаггүй, өөрийн мөн чанарын хүчээр, өөрийнхөөрөө оршдог, ямар ч тийм мөн чанар байхгүй” (Е.А.Торчинов 2000, 85) хэмээн бичсэн байна. Мөн ерөөс буддизм бол өөрийн би хэмээхээс татгалзахаас гадна, би биш хэмээхийг ч үгүйсдэг үзэл(Oh

2022, 46-97) болох тухай судлаачид дүгнэсэн байна. Мадхьямика философийг үндэслэгч Нагаржунын философийг шүтэн барилдахуй хэмээн тайлбарлах нь орчин үеийн нийгэмд илүү ойлгомжтой, практик ач холбогдолтой гэж философийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Б.Даш-Ёндон “Нагаржунын гүн ухаан (Шүтэн барилдахуйн онол)” хэмээх номын оршил хэсэгтээ тэмдэглэсэн байна. Тэр бичихдээ “Нагаржунын гүн ухааныг хоосон чанарын онол гэхээсээ шүтэн барилдахуйн онол гэвэл сонирхогч, ухаарахыг хичээгсдийн тоо нэмэгдэх бизээ хэмээн санагдмуй”(Б. Даш-Ёндон 2016, 12) гэсэн байна. Мөн Даш-Ёндон доктор шүтэн барилдахуй гэж юу вэ гэдгийг “Буй-д холбогдож инагуухийн туйлшрал гарна. Үгүй-д холбогдож чинагуухын туйлшрал гарна. Гэхдээ энэ хоёрыг даван туулж шүтэлцүүлбэл бодит үнэнд хүргэнэ” (Б.Даш-Ёндон 2016, 13) гэсэн байна. Өөрөөр хэлбэл, түүний үзлээр мадхьямика философийн гол утга нь “юу ч байхгүй” эсвэл “юм байна” гэх аливаа туйлшралаас ангижирч, аливаа юмыг аль аль талынх нь харилцан холбоонд нь авч үзэж байх тухай санаа юм. Даш-Ёндон докторын энэхүү тайлбартай бид санал нэг байгаа хэдий ч гагцхүү шүтэн барилдахуй гэх ойлголтын хувьд эргэлзээ төрж байгаа юм. “Шүтэн барилдахуй” гэсэн холбоо үгийн барилдахуй гэсэн үг нь гарвал зүйн хувьд барилдах, ноцолдох гэсэн үгээс гаралтай хэмээн таамаглаж байна.

Барилдахуй хэмээх үгийг монгол хэлний тайлбар толиос мөшгин харвал барилдах буюу 1. Наалдан зууралдаж салгахад хэцүү болох, 2. Ноцолдон тэнхээгээ сорих(Я.Цэвэл 1966, 76) гэсэн утгаар тайлбарласан байна. Харин Г.Лувсанцэрэн гуай бичихдээ “Юмс хоосон чанартай гэдэг бол юм байхгүй хоосон гэсэн үг биш, харин юм бие даан, эгнэгт оршихыг үгүйсгэсэн, юмыг хоорондын шүтэн барилдлага, харьцангуй чанарт нь авч үзнэ гэсэн хэрэг болно”(Г.Лувсанцэрэн 1981) хэмээн бичжээ. Энэ өгүүлбэрийн барилдлага хэмээх үгийг авч үзвэл: 1.учрал, тохиол, 2. зурхайн ёсны од гаригийн тохиол, 3. бат холбоо, ах дүүгийн барилдлага (Я.Цэвэл 1966, 76) гэсэн утгатай гэсэн байна. Мөн шүтэн барилдлага гэсэн үгийн шүтэн гэсэн үг нь шүтэх гэсэн үгээс гаралтай бөгөөд гүнээ итгэх бишрэх (Я.Цэвэл 1966, 863) гэсэн утгатай гэжээ. Тэгэхээр шүтэн барилдлага гэдэг үг нь шууд утгаараа гүнээ итгэж биширсэн бат холбоо болж байгаа юм. Энэ философийн нэрийг дундад, төв үзэл гэх нь зөв ч гэсэн утгыг нь бид юу гэж орчин үечүүлж тайлбарлах вэ гэсэн асуулт л бидний сонирхлыг татаж байна. Г.Лувсанцэрэн гуай бол юм оршин байх өнцгөөс нь хоосон чанарын философийг тайлбарласан байна. Гэтэл дундад үзлийн философийг тайлбарлагчид энэ философийг онтологи, танин мэдэхүйн утгаар нь төдийгүй, ёс суртахууны агуулгаар тайлбарлах нь бий. Жишээ нь, буддизмыг өрнийн философийн Кантын философитой харьцуулж үзвэл илүү ойлгомжтой болно.

Кант бол зөвхөн хүнд өөрт нь хамааралтай ертөнцийг ноумены ертөнц, харин хүнээс үл хамаарах шалтгаан үрийн холбоонд орших ертөнцийг феномены ертөнц хэмээн ангилсан байдаг. Бид бол мөн адил хоосон чанарын философийг Кантын энэхүү ноумены ертөнцтэй төстэй байдлаар авч үзэх нь зүйтэй болов уу хэмээн таамаглаж байгаа юм. Нөгөө талаас Кантын эрс императив буюу ёс суртахууны давж үл болох шаардлага буюу өөртөө хүсэхгүй байгаа зүйлээ бусдад бүү хий гэсэн алтан дүрэм бол бусдыг зорилгынхоо хэрэгсэл бүү болго гэсэн утгатай билээ. Мадхьямика философид ярьдаг бодхисатва бол яг л бусдыг зорилгынхоо хэрэгсэл гэж бус, харин бусдын дунд амьдардаг гэдгээ бүрэн ухамсарласан, энэ түвшинд хүртлээ олон үе

шатыг давсан харилцан оршихуй юм. Бүр цашилбал бодхисатваг феноменологи философийн төлөөлөгч Гуссерлийн дэвшүүлсэн цэвэр ухамсартай адилтган үзэж болох юм. Бодхисатва нь цэвэр ухамсрын түвшинд хүртлээ 10 үе шатыг дамждаг тухай философийн шинжлэх ухааны доктор И.С.Урбанаева “Абхисамайаламкара” шастираас эш авч тайлбарласан байна. Гэхдээ мадхьямика урсгал чиглэлд ухамсрын түвшнүүдийн онцлогийг тэр бүр ялгаж тайлбарлаад байдаггүй, харин йогачара урсгалд бол ялгаж үздэг” (И.С.Урбанаева 2016, 243) гэсэн байна. Ерөөс мадхьямика философи бол нирванд буюу цэвэр ухамсрын түвшинд хүрэх зорилготой бодхисатвын давах ёстой нэг шат ч байж болох юм. Өөрөөр хэлбэл, дундын тухай сургаал нь (мадхьямика нь) бүх зүйл мөн чанартаа хоосон тухай сургаал бус, харин өөрийгөө энэ ертөнц дээр ганцаараа, бие даан оршдоггүй гэдгээ, мөн бусадтай харилцан оршихоо ухаарч буй ухамсрын түвшин юм.

Их хөлгөний буддизмын нэгэн чухал чиглэл болох дундад үзлийн тухай Монголын болон гадаадын эрдэмтэн судлаачид сүүлийн үед олон арван бүтээл бичиж байгаагийн нэгэн жишээ бол философийн шинжлэх ухааны доктор, профессор Сергей Юрьевич Лепеховын “Их хөлгөний буддизмын шашин-философийн болон логик-танин мэдэхүйн онолууд” хэмээх нэгэн сэдэвт бүтээл юм. Тэрээр өмнө нь “Их хөлгөний философи ба буддын иргэншлийн үүсэл” (Улан-Удэ, 1999. 238 с.), “Буддизмын герменевтик” (Улан-Удэ, 2006. 264 с.) (А.М.Донц, С.П.Нестеркин нартай хамтарсан); “Японы сонгодог уран зохиол дахь лам шашин ба буддын үзэл санаа” (Улан-Удэ, 2013. 445 с.) (Е.С.Лепеховатай хамтарсан) зэрэг нэг сэдэвт бүтээлүүдийг бичжээ. Лепехов тус бүтээлдээ их хөлгөний буддизмын үндсэн онол, ойлголтын тогтолцоо бүрэлдэн тогтсон үйл явцыг судалж улмаар энэхүү ойлголтын тогтолцоог хэрэглэхэд нөлөөлсөн янз бүрийн арга хандлагуудыг харьцуулан шинжлэхийг зорьсон байна. Мөн зохиогч энэхүү номынхоо хавсралт хэсэгт билиг барамидын судрууд болон Нагаржунагийн шастируудын орос хэл дээрх өөрийн орчуулгыг оруулсан байна. Энэхүү нэг сэдэвт бүтээл нь үндсэн хоёр бүлэгтэй бөгөөд нэгдүгээр бүлгийн нэр нь “Мадхьямика дэг сургууль болон “төгс мэргэн ухааны” тухай шашин-философийн сургаал бий болсон нь” сэдэвтэй, харин хоёрдугаар бүлэг нь “Их хөлгөний буддизмын онтологийн ба логик-танин мэдэхүйн ойлголтын тогтолцоо” гэсэн нэртэй юм.

Эхний бүлэгт зохиогч буддизмыг эртний Энэтхэгийн философийн бусад урсгал чиглэлүүдээс ихээхэн ялгаатай, онцлог байдлаар үүсэж бий болсныг, энд *үнэн* (истина) *ба гэгээрэл* (освобождение) гэсэн хоёр ойлголт салшгүй холбоотой бөгөөд нэг нь нөгөөгөө илэрхийлж байдаг гэсэн байна. Үүнтэй холбоотой бас нэг ойлголт бол *бясалгал* (уединение) юм. Энэ нь йогийн практикт нэвтэрсэн бөгөөд үүнийг Шагжамуни Будда өөрөө ч мөн туршиж үзсэн ба харин тэр дараа нь аливаа туйлшрал бол зорилгодоо хүрдэггүй учраас хүн өөрөө оюун, мэргэн ухаанаа уралдуулж, туйлшралаас ангижирч, “дундад замыг” олоход чармайх нь зөв тухай сургажээ. Ийнхүү их хөлгөний дэг сургууль болон “төгс мэргэн ухааны” тухай шашин-философийн сургаал бий болсон тухай зохиогч өгүүлсэн байна. Цаг хугацаа өнгөрч Шагжамуни Буддагийн үзэл сургаалийг үргэлжлүүлж, хөгжүүлсэн олон урсгал чиглэлүүд хөгжиж, улмаар буддын гэгээрэлд хүрэх цоо шинэ арга техникийг санал болгосон билэг барамидын бичвэрүүд гарч ирсэн байна. Энэхүү чиглэлийн хамгийн гол ойлголт бол “Төгс мэргэн ухаан” бөгөөд энэ нь гэгээрэлд хүрэх гол

хэрэгслүүдийн нэг юм. Харин гэгээрэлд хүрэх арга зам бол бодьхисатвавагийн зам юм. Бодьхисатва бол **өөрийн амьдрал үйл ажиллагааг бусад амьд амьтдыг аварч хамгаалахад чиглүүлсэн ухамсарт оршихуй** (С.Ю.Лепехов 2022, 24) юм.

Энд бидний санал болгоод буй харилцан оршихуй хэмээх ойлголтын утга тодорхой болж байна. Билиг барамидын сургаалуудын олон үзэл санаа, зарчмууд нь “Их хөлгөн (Великая колесница)” хэмээх Махаянад ихээхэн нөлөө үзүүлсэн. Энэ нь Энэтхэгээс Хятад, Солонгос, Япон, Түвэд, Монгол гэх зүүн ба зүүн өмнөд Азийн улс орнуудад тархжээ гэсэн байна. Мөн бидний үзэж байгаагаар их хөлгөн гэх энэ ойлголтын хөлгөн гэсэн үгийн гарал үүслийг мөшгөн харвал хөлгөн хэмээх нь хөлөг хэмээх үгийн язгууртай бөгөөд хөлөг гэх энэ үгэнд үндсэн дөрвөн утга байдаг. Үүнд, хөлөг онгоц, хүндэтгэвэл зохих хүний уналга, баатар, шатар зэрэг тоглоомын өрж наадах тавиур (Я.Цэвэл 1966, 709) гэсэн байна. Тиймээс бид хөлгөн гэсэн үгийн утга бол хөлөг морь, хөлөг онгоц гэх мэт замтай холбоотой үгийг илтгэж байгаа юм. Ерөнхийдөө хинаяна ба махаяана хоёрын утга нь бага, их зам мөр (Е.А.Торчинов 2000, 48) гэсэн шууд утгатай болохыг мөн Торчинов дурдсан байна. Их бага хөлгөн хэмээх энэ ангиллыг мэдээж хэрэг их хөлгөний чиглэлийнхэн гаргаж ирсэн болов уу хэмээн Торчинов таамаглаж байгаагаа мөн илэрхийлсэн байна.

Их хөлгөний философийн урсгал чиглэлүүдийн нэг чухал нь Мадхьямика юм. Энэ нь Шагжамуни Буддагийн түгээн дэлгэрүүлсэн “дундад зам мөрийг” үргэлжлүүлж буй “**дундадын тухай**” сургаал юм. Лепехов дүгнэхдээ билиг барамидын сургаалыг эхнээсээ философийн уншлага байсан ба харин Мадхьямака нь энэхүү сургаалд байх далд бүхнийг нээн хөгжүүлсэн юм гэсэн байна. Мадхьямакийн тухай Оросын нэрт будда судлаач Е.А.Торчинов “Мадхьямика бол би хэмээхийн өндөр мэдрэмжтэй, би хэмээх рүү нэвт шувт нэвтэрсэн хүмүүсийг анагаах “эм”, харин йогачара философи бол гадаад ертөнцийн юмс үзэгдэлд хэт шунасан хүмүүсийг анагаах “эм” юм (Е.А.Торчинов 2000, 78) хэмээн оновчтой байдлаар тодорхойлсон юм. Үнэхээр бид Торчинов гуайтай санал нэг байгаа бөгөөд дундын тухай сургаал буюу мадхьямика нь би хэмээх үзэл рүү хэт туйлширсан, амиа бодсон, бусад хүмүүсийг өөрийн зорилгын хэрэгсэл болгодог хүмүүсийг анагаах, өөрөөр хэлбэл ийм хүмүүсийг хүмүүжүүлэх сургаал юм. Мөн Лепехов дээрх бүтээлдээ их хөлгөний бас нэг өөр чиглэл болох Виджняваг ч гэсэн мөн дээрхийн адилаар билиг барамидыг хөгжүүлсэн ба ерөөс буддын их хөлгөний урсгал чиглэлүүд нь хийд, лам нар болон сүсэгтэн олон гэсэн хэлбэртэйгээр практик амьдралд нэвтэрч улмаар тархсан орнуудынхаа эдийн засаг, нийгмийн хүрээ, улс төр, урлаг, уран зохиол, гар урлал гэх мэт амьдралын бүхий л хүрээг хамарсан юм. Энэ сургаал нь одоо ч гэсэн үнэ цэнээ алдахгүй, орчин үеийн олон асуудалд шийдэл болох чадвартай, чухал ач холбогдолтой байсаар байна хэмээн Лепехов дүгнэсэн байна.

Ерөнхийдөө буддын судлаачдыг, тэр дундаа их хөлгөний буддизмын тайлбаруудыг нэрт дорно дахины судлаач Е.А.Торчинов нь үгүйсгэх, харьцангуй, үнэмлэхүй ба шүүмжлэлт хэмээх ангилалд хувааж үзсэн байна. Буддизмын хамгийн сүүл үеийн буюу шүүмжлэлт үеийн судлаачид бол түрүү үеийнхээ судлаачдыг бодвол илүү ихээр эх зохиолтой танилцах боломжтой болсон бөгөөд учир нь

Түвэд дэх 1959 оны Хятадын эсрэг бослогоор Түвэдийн олон зуун лам нар баруун луу явцгаасан (Е.А.Торчинов 2000, 84) юм гэсэн байна. Тийм учраас Лепеховын дурдсан бүтээл ч гэсэн эх зохиол дээр ажиллаж, буддизмын үзэл сургаалын онтологи, логикийн байгууламжийг яг тэр чигт нь давтах гэхээсээ илүү түүний деконструкц (байгууламжийг эвдэхүй) болсон байна хэмээн бид үзэж байна.

Мөн Лепехов нь буддизмыг зөвхөн шашин гэх утгаар бус, харин философи, шинжлэх ухаан, утга уран зохиол, урлаг, улс төр, эдийн засаг гэх мэт соёлын болон практикийн өргөн хүрээнд авч үзсэн байна. Тухайлбал, тэрээр номын нэгдүгээр бүлэгтээ их хөлгөний буддизмын эхэн үе нь Маурьгийн үе бөгөөд энэ үед Энэтхэгийн баруун хойд хэсгийг Грекийн эзлэн түрэмгийлэгчид дайрч байсныг, үүний үр дүнд грекийн болон буддын философийн уламжлалууд “Милинда-паньха” сударт нэгдэн нийлж байсан (С.Ю.Лепехов 2022, 29) зэрэг дүгнэлтүүдийг хийсэн нь ихээхэн сонирхол татаж байгаа юм. Лепеховын энэхүү байр суурь нь нэрт будда судлаач Е.А.Торчиновын “буддизм бол нэг шашны олон урсгал чиглэл бус харин тус тусдаа олон урсгал чиглэл байдлаар хөгжиж ирсэн юм” (Е.А.Торчинов 2000, 19) гэсэн байр суурийг санагдуулж байна. Мөн Лепехов нь буддизмын хөгжлийг улс төр, эдийн засгийн гэх мэт практик амьдралтай нь илүү их холбож авч үзэхийг зорьсон байна.

Мөн Лепеховын энэ бүтээлд их хөлгөний буддизмыг бодит мөн чанарлаг өнцгөөс хардаг феноменологи хандлагыг мөн нөгөө талаас ойлголтыг эдүгээчлэн тайлбарладаг герменевтик, мөн түүхэн харьцуулалтын аль аль арга зүйг хослуулан хэрэглэсэн байгаа юм. Тухайлбал, тэрээр христийн шашинд өгүүлдэг аврал гэх ойлголтыг буддын шашны гэгээрэл гэсэн ойлголттой харьцуулан авч үзсэн байна. Тэр бичихдээ буддизмд “аврал” гэх ойлголт бол ямар нэг шашны зүтгэлтэнд, эсвэл өөрийгөө золиосолдог бие хүн, түүний үйл ажиллагаанд хамааралтай ойлголт биш, харин Дээд бүрэн төгс гэгээрэл бол өөрийн Би, оршихуй, амьдралыг байхгүй хэмээх байр суурь юм (С.Ю.Лепехов 2022, 29) гэсэн байна. Ер нь буддын шашны гэгээрэл хэмээх ойлголтын мөн чанарыг үе үеийн олон будда судлаач, эрдэмтэн нар оновчтой байдлаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, мөн тус хүрээлэнгийн судлаач, доктор Ирина Сафронова Урбанаева нь “Буддын философи ба практик: гэгээрэлд хүрэх агшин зуурын ба/эсвэл аажим арга зам” хэмээх бүтээлдээ гэгээрлийн арга зам гэж юу болохыг онтологи, танин мэдэхүйн үүднээс, мөн энэ төрлийн судалгааны олон арвин бүтээлүүдийг харьцуулан авч үзсэний үндсэн дээр дэлгэрэнгүй шинжлэн үзсэн байна. Тухайлбал, Урбанаева нь дээрх бүтээлдээ хоосон чанар (пустотность) хэмээх ойлголтыг нэрт будда судлаач дэлхийн эрдэмтэн нар болох Ясперс, Ф.И.Щербатской, Е.А.Торчинов, Мурти, О.О.Розенберг зэрэг эрдэмтдийн бүтээлээс харьцуулан шинжлэн үзсэн байна. Ингэхдээ мөн Түвэд-Монголд дэлгэрсэн буддизмын уламжлалыг ихээхэн түлхүү байдлаар авч үзсэн нь Монгол судлал, Монголын философийг судлан шинжлэхэд онол арга зүйн хувьд ач холбогдолтой бүтээл болсон байна. Урбанаева дээрх номдоо буддизмыг дорнын сэтгэлгээ, азийн философи гэж овоглох нь буруу, энэ бол улс орон бүрийн соёл иргэншлээс шалтгаалж маш онцлог бүхий урсгал чиглэл болж хөгжиж ирсэн үзэгдэл хэмээн үзсэн нь арга зүйн маш чухал байр суурь хэмээн бид дүгнэж байгаа юм. Мөн тэр дүгнэхдээ “Монгол, халимаг, буриад, тувад дэлгэрсэн буддизмын Түвэд уламжлал бол... буддизмын илүү бүрэн бүтэн тогтолцоо бөгөөд хятадын

буддизм бол үүнтэй харьцуулахад буддизмын шилжсэн хэлбэр юм” (И.С.Урбанаева 2016, 127) гэсэн байна.

Мөн Лепеховын дээрх номын “Их хөлгөний буддизмын онтологийн ба логик-танин мэдэхүйн концепц” хэмээх хоёрдугаар бүлэг бол хамгийн чухал хэсэг нь бөгөөд энэ бүлэгтээ зохиогч атом, ухамсар, дхарма, танин мэдэхүй, хоёр үнэний тухай Нагаржунагийн үзэл гэх зэрэг ойлголтууд нь их хөлгөний буддизмд хэрхэн бүрэлдэн тогтож ирснийг орчин өрнийн философийн ойлголтуудтай харьцуулан авч үзсэн байгаа нь тус номыг орчин үеийн иргэний боловсролд хэрэглэж болохоор чухал хэрэгдэхүүн болгож байгаа юм.

Лепехов нь энэхүү номондоо Их хөлгөний буддизмын тэр дундаа Нагаржунагийн философийг тайлбарлахдаа шууд их зохиолыг нь ашигласан байна. Тухайлбал, тэр номын хоёрдугаар бүлгийн тавдугаар зүйлд бичихдээ “Нагаржуна нь ‘Ертөнцийн гэх зүйлээс ангижирсан тухай магтаал (Локатитастава)’-д (Энэ зохиолын нэрийг Монгол Данжуурт ‘Ертөнцөөс нөгчсөн магтаал’ хэмээн орчуулсан байна (Б.Даш-Ёндон 2016, 274)) ухамсрын асуудалд хандахдаа танин мэдэхүйн арга зүйг хэрэглэсэн...Буддын арга зүйн хувьд тэмдэг ба тэмдэглэгдэгч хоорондын харилцаа холбоо байна гэдэг нь **хоорондоо холбоо харилцаа бүхий үйл явдал эсвэл үзэгдлийн бие даасан мөн чанар үгүйг илтгэнэ**” (С.Ю.Лепехов 2022, 151) гэсэн байна. Ийнхүү Лепехов Нагаржунагийн дээрх бүтээлээс шууд ишлэн тайлбарлажээ. Үүнд, “тэмдэг ба тэмдэглэгдэгч нь ялгаатай ч биш, бодитой оршдог ч биш юм” (С.Ю.Лепехов 2022, 346) гэжээ. Яг энэ өгүүлбэрийг Монгол Данжуур, Магтаалын чуулганд “Бэлгэ чанар бэлгэдэх ангид нь, Бэлгэдэх бэлгэ чанар үгүй болно, Тус бүр болбоос ч тэр үгүй еэ, Чи бээр тодорхой яа чухам үзүүлэв” (“Цогт цагийн хүрдэн” ТББ 2011, 146) гэсэн байна. Бидний хувьд дээрх Монгол орчуулгыг уншаад юу ч ойлгохгүйгээр барахгүй, энэ өгүүлбэрт орчин цагийн Монгол хэлний өгүүлбэр зүйн ямар ч зөв бүтэц харагдахгүй байгаа юм.

Харин Лепеховын дээрх орчуулгаас бол бид тэмдэг ба тэмдэглэгдэгч хоёр нь тус тусдаа юу ч биш, эс оршдог, харин харилцан орших тухай санааг ойлгож байгаа юм. Мөн түүний арай өмнөх өгүүлбэрт “Танин мэдэхүйн объект нь мэдлэггүй байх боломжгүй, гэвч танин мэдэгч ухамсар нь танин мэдэхүйн объектгүй байх боломжгүй, тиймээс чиний хэлснээр танин мэдэхүй ба түүний объект нь тус тусдаа өөрийн мөн чанаргүй юм” (С.Ю.Лепехов 2022, 346) хэмээн Лепехов орчуулсан байна. Эндээс бид мадхьямика философийн харилцан оршихуйн утгыг бүрэн дүүрэн илтгэх санааг олж авч байна. Танин мэдэгч, танин мэдэхүйн чадвар, танин мэдэж буй объект гурав нь хамтран, харилцан оршиж байж сая танин мэдэхүй нь боломжтойг дээрх өгүүлбэрт Нагаржуна өгүүлсэн байна. Харин Монгол орчуулгыг харьцуулан үзүүлбэл “Мэдэл үгүй еэ мэдэх бус Тийн үгүй тийн ч үгүй Тиймийн тул мэдэгдэхүүнүүд Өөрийн бодис үгүй хэмээн чи бээр номлов” (“Цогт цагийн хүрдэн” ТББ 2011, 146) гэсэн байна. Энд ч мөн нөхцөл байдал адил байгаа юм. Монгол данжуурыг хөрвүүлэгч нар номын хамгийн сүүлийн хуудсандаа Монгол эхийн үг хэллэгийг хэвээр буулгав (“Цогт цагийн хүрдэн” ТББ 2011, 645) гэсэн байна. Үнэхээр ч иймэрхүү төрлийн орчуулга бол орчин цагийн хүмүүст ойлгомж муутай, хэт архаик шинжтэй байсаар байна.

Дунддын тухай үзлийн харилцан оршихуйн тухай санааг бид академик чиглэлийн ном, судалгааны бүтээлүүдээс эсвэл шашны агуулга бүхий хуучин ном

зохиолоос төдийгүй, ерөөс Монголын орчин үеийн утга уран зохиолоос ч харж болно. Амьдрал, цаг хугацааг орчилт шинжтэй, бидний үр хүүхэд бол бидний оршихуйн үргэлжлэл, харилцан оршихуй юм гэсэн санааг 2019 оны “Болор цом”-ын эзэн болсон яруу найрагч Б.Баттулгын “Мөнгөн шөнөөр” шүлгийн бадгуудаас харж болно. Үүнд, “... эхлэл нь замхравч төгсгөл нь эхэлдэг орчлон юм, ээж нь охиндоо эргэж төрдөг хорвоо юм, дуу нь намдавч цуурай нь шуранхайлдаг ертөнц юм, дурдатгалын шидэт гүүрээр ирээдүйд зорчих тавилан юм...”(<https://www.youtube.com/watch?v=RGYCYU6ychY> 2019) гэсэн байна.

V. Дүгнэлт

Ийм учраас орчин цагийн Монголчуудын хувьд дунддын тухай философи (мадхьямика) нь одоог хүртэл ач холбогдолтой, хүний амьдралыг ойлгох суурь нь, харилцан оршихуйн философи нь байсаар байгаа юм. Гагцхүү бид буддын философи, үзэл санааг зөвхөн архаик хэл, утгаар тайлбарлах биш, орчин үеийн уран зохиол, шинжлэх ухаан, цаашилбал, хууль эрх зүй, улс төр, иргэний утгаар тайлбарлаж, илэрхийлэх хэрэгцээ шаардлага байгааг л онцлон дахин дурдах нь илүүц биз ээ.

Ашигласан материал

- Jin Y.Park. 2023. “Chapter outline. Action and praxis.” In *Key concepts in world philosophies. Part one. How we acquire knowledge about ourselves and reality.*, 16. Bloomsbury publishing.
- Гантуяа М. 2021. *Буддын авидармын ба билиг барамидын эх сурвалжийн харьцуулсан шинжилгээ. Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл.* Улаанбаатар: МУ-ын ШУА, Философийн хүрээлэн.
- Торчинов Е.А. 2000. *Введение в буддологию. Курс лекций. Лекция 5. Классическая буддистская философия: Мадхьямика (Шуньявада).* Санкт-Петербург.
- Oh, Whachul. 2022. “Understanding of Self: Buddhism and Psychoanalysis.” *Journal of religion and health* 46-97.
- Даш-Ёндон Б. 2016. *Нагаржунын гүн ухаан, ёс зүй (Шүтэн барилдахуйн онол).* Улаанбаатар хот.
- Цэвэл Я.1966. *Монгол хэлний товч тайлбар толь.* Уб: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.
- Лувсанцэрэн Г. 1981. *Нагаржунагийн философийн үзэл.* Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэр.
- Урбанаева И.С. 2016. *Буддийская философия и практика: “постепенный и/или “мгновенный” путь просветления”.* Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, стр. 243
- Лепехов С.Ю. 2022. *Формирование религиозно-философских и логико-эпистемологических концепций буддизма махаяны.* Иркутск: Отгиск.
- “Цогт цагийн хүрдэн” ТББ. 2011. *Монгол Данжуур. Магтаалын чуулган.* Улаанбаатар: Монгол бичгээс хөрвүүлэв. “Цогт цагийн хүрдэн” ТББ. 146 дахь тал.
2019. <https://www.youtube.com/watch?v=RGYCYU6ychY>. Accessed 08 30, 203. 11:30.
- Урбанаева И.С. 2016. *Буддийская философия и практика: “постепенный и/или “мгновенный” путь просветления”.* Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН .
- “Цогт цагийн хүрдэн” ТББ. 2011. *Монгол Данжуур. Магтаалын чуулган (Монгол бичгийн хөрвүүлэг).* Улаанбаатар: “Цогт цагийн хүрдэн” ТББ.